

## ТӨВДӨЧ ЭРДЭМТЭН Л.ХҮРЭЛБААТАРЫН УТГА ЗОХИОЛ СУДЛАЛЫН БҮТЭЭЛҮҮД

Х.Сүглэгмаа

### Abstract

*The research works and materials of the Mongolian study of XX century, especially researches on relationship of culture, religion and literature of Mongolia, Tibet and India, study of Tibetan written literature or Mongolian ancient literal by L.Khurelbaatar, Sc.D, professor, tibetist and literator are reviewed in this article.*

Л.Хүрэлбаатар 1970-аад оны дунд үеэс “Шинээр олдсон төр ёсны нэгэн шастир”<sup>1</sup>, “Зохиолч Ишсамбуугийн намтар, уран бүтээлээс”<sup>2</sup>, “Ишсамбуугийн нэгэн зохиол «Зохист аялгууны толь»-той холбогдох нь”<sup>3</sup>, “Эрдэнийн галбарвасан мод”<sup>4</sup>, “Төвд хэлээр бичсэн нэгэн сургаалын шүлэгт хийсэн ажиглалт”<sup>5</sup>, “Монгол хэлэнд орсон санскрит үг”<sup>6</sup> зэрэг эрдэм шинжилгээний анхны өгүүлэл, илтгэлүүдээ хэвлүүлж эхэлсэн нь тухайн үедээ Монголын уран зохиол судлалаар зайлшгүй яригдах ёстой урьд нь төдийлөн хөндөгдөөгүй асуудлыг авч үзсэн байдгаараа анхаарал татаж эхэлсэн юм. Төвд хэлт уран зохиолын асуудал хөндсөн эдгээр бүтээлээсээ цаашид, 1980-аад оны эхнээс ихэвчлэн Энэтхэг, Төвд, Монголын уран зохиолын харилцаа холбоо, уран зохиолын уламжлал шинэчлэл, эдгээрт нөлөөлсөн монгол орчуулгын өв уламжлал гэсэн гурван гол чиглэлээр түүний судалгаа шинжилгээ гүнзгийрсэн байна. Ингэхдээ Энэтхэг, Төвд, Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудлаар “Төвд, монгол Данжурын доторх төр ёсны найман шастир”<sup>7</sup>, “Восемь нити-шастр из тибето-монгольской энциклопедии «Данджур»”<sup>8</sup> “Төвдөөр бичсэн сургаал үлгэрийн нэгэн цоморлог”<sup>9</sup>, “«Субашид»-аас уламжлалтай Монголын “хос ёсны” сургаал”<sup>10</sup>, “Төвд, Ганжур, Данжур, түүний монголд дэлгэрсэн нь”<sup>11</sup>, “Б.Я.Владимирцовын судалгаа, Энэтхэг, Төвдийн уран зохиолтой холбогдол бүхий монгол зохиол”<sup>12</sup>, “Энэтхэг, Төвд, Монголын утга зохиол, түүх, соёлын харилцааны уламжлал”<sup>13</sup>, “Дандийн «Зохист

1 Монголын судлал. III (II) боть. 21-р дэвтэр. Улаанбаатар., 1975. 71-86.

2 Хэл зохиол судлал. XI боть. 22-р дэвтэр. Улаанбаатар., 1975. 261-270.

3 Хэл зохиол судлал. XIII боть. 25-р дэвтэр. Улаанбаатар., 1977(79). 270-277.

4 Аман зохиол судлал. 1977. X боть. 4-р дэвтэр. Улаанбаатар., 69-86.

5 Хэл зохиол судлал. XIV боть. 23-р дэвтэр. Улаанбаатар., 1978(80). 173-176.

6 Монголын судлал. IX боть. 15-р дэвтэр. Улаанбаатар., 1981 (1982). 210-245.

Олон улсын монголч эрдэмтний III их хурлын эмхтгэл. III боть. Улаанбаатар., 1979. 268-273.

7 Монголын судлал. IX боть. 15-р дэвтэр. Улаанбаатар., 1981 (1982). 210-245.

8 Реферативный журнал. (Общественные науки за рубежом, Литературоведение). Серия 7. Москва., 1984. 94-96.

9 БНМАУ-ын шинжлэх ухааны байгууллагын 60, ШУА-ийн 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын сэдэв. Улаанбаатар., 1981. х.43-44;

Mongolica (An International annual of Mongol Studies). Vol 2/23/. 3/24/. 1991. 1992. Ulaanbaatar., 215-229.

10 Олон улсын монголч эрдэмтний IV их хурлын эмхтгэл. II боть. Улаанбаатар., 1985. 160-173.

11 Монголын судлал. XIII (21) боть. 9-р дэвтэр. Улаанбаатар., 1987. 47-71;

Өвөрмонголын Нийгмийн Шинжлэх Ухаан. 3.4. Дугаар 46, 47. Хөххот., 1990. 121-133.

12 Хэл зохиол судлал. XX боть. 4-р дэвтэр. Улаанбаатар., 1987. 21-25.

13 Дорно дахины судлалын асуудал. №2. Улаанбаатар., 1988. 42-47.

аялгууны толь»-ийн төвд, монгол тайлбаруудын харьцаа<sup>14</sup> зэрэг өгүүлэл, илтгэлүүд; монгол яруу найргийн уламжлал шинэчлэлийн асуудлаар “Монголын уянгын яруу найраг дахь “хүслийн” тухай сэдвийн уламжлал, шинэчлэл”<sup>15</sup>, “Равжаагийн уран бүтээлд холбогдох зарим мэдээ”<sup>16</sup>, “Монгольский поэт XIX века Дулдуйтын Равжа (1803-1856)”<sup>17</sup> “Бичгийн болон ардын яруу найргийн зохиомж дахь “таван хүслийн” бэлгэдэл”<sup>18</sup>, “Яруу найргийн онолын өв”<sup>19</sup>, “Дууллын шүлгийн уламжлал ба гүн сэтгэлгээний уянга”<sup>20</sup>, “Монголын яруу найргийн уламжлал, шинэчлэл (Яруу найргийн судлал, шүүмж)”<sup>21</sup> зэрэг өгүүлэл, илтгэлүүд; монгол орчуулгын өв уламжлалын тухайд “Гүүш цоржийн тухай төвд, монгол сурвалжийн зарим мэдээнд хийсэн ажиглалт”<sup>22</sup>, “Монголчуудын орчуулгын уламжлалын тухайд (“Субашидын” орчуулгын жишээн дээр хийсэн судалгаа)”<sup>23</sup>, Монгол “Оюун түлхүүрийн” нэгэн төвд орчуулгын тухай”<sup>24</sup>, “XVI-XVII зууны үеийн уран сайхны орчуулгын уламжлалаас (Гүүш цоржийн орчуулгын жишээн дээр хийсэн судалгаа)”<sup>25</sup> зэрэг өгүүлэл, илтгэлүүдийг тус тус гадаад дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл, хэвлэлүүдэд нийтлүүлсэн байна.

Монголын эртний уран зохиол, тэр дундаа төвд хэлт уран зохиол, онол туурвил зүйн сэтгэлгээний шинэчлэл, түүнд нөлөөлж уран зохиолын хөгжлийн нэгэн салаа мөчир болж ирсэн уран зохиолын орчуулгын өв уламжлалын асуудал, Энэтхэг, Төвд, Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудал дээр суурилсан Л.Хүрэлбаатар багшийн утга зохиол судлалын бүтээл 1990-ээд оны эхэн үеэс уран зохиолын төрөл зүйл, тэдгээрийн гол төлөөлөгчдийн бүтээлийг тусгайлан авч үзэх, улмаар Монголын аман бичгийн уран зохиолын харилцаа холбооны асуудал, Монголын уламжлалт шашин соёл, зан үйлийн уламжлал ба уран зохиолын харилцаа холбооны асуудлаар өргөжин дахин нэг шат гүнзгийрч ирсэн байдаг. Энэ нь Монголын эртний уламжлалт уран сайхны сэтгэлгээний нийтлэг хэв маяг дээр хөллөсөн, ихэвчлэн буддийн, дорно дахины ард түмний аж төрөхүйн гүн ухааны баялаг өв уламжлалтай, нэг талаас уран зохиолын, нөгөө талаас түүх, шашин, соёлын олон талт уламжлалыг хадгалсан, төвд монгол хэлээр бичигдсэн олон арван дурсгалыг тэр тус бүрий өөр өөрийн хүрээ хявцаанд нь явцууруулан нэгэн зүйлд хашиж шахалгүй, сэтгэлгээний өргөн дэлгэр дэвсгэр, учир шалтгааны олон талт харилцаа холбоон дундаас нь судалж шинжлэх боломжийг давхар харуулснаараа онцлог болсон юм. Уран зохиолын түүхийг тоймлон үзэх төдийгөөр хязгаарлагдаж байсан өмнөх үеийн судлаачдын бүтээлийг ийнхүү уран зохиолын төрөл зүйлийн түвшинд нарийсган авч үзэж, захиа бичиг, зам явахын уран зохиол, үг зохиол, намтар зохиол, дууллын, сургаалын, магтаалын тахил төгсгөлийн, залбирал шүлэг, гүр дуу, хориг шүүмжийн бичгийн гэх мэт хэдэн арван төрөл байгааг ““Үнэрт шилэн эрх”-нээс үүдэн өгүүлэхийн учир (Зава Дамдин

14 Монгол ба Энэтхэг. Улаанбаатар., 1989. 204-211.

15 Шинжлэх ухааны академийн мэдээ. №3. Улаанбаатар., 1985. 75-83

16 Шинжлэх ухааны академийн мэдээ. №2. Улаанбаатар., 1986. 96-100.

17 Зарубежный Восток. Литературная панорама. Выпуск семнадцатый, Москва., 1989. 382-393.

18 Аман зохиол судлал. XVII боть. II дэвтэр. Улаанбаатар., 1987. 10-28.

19 Цог. №2, Улаанбаатар., 1989. х.82-88; Утга зохиол судлалын унших бичиг. I. Улаанбаатар., 1996. 180-191.

20 Утга зохиолын шүүмжлэл-86. Улаанбаатар., 1989. 128-152.

21 Билгийн толь- II. Монголын уран зохиолын дээжис. Улаанбаатар., 1998. 178-195;

Утга зохиол, урлаг сонин. 1989 оны IV сарын 7. № 15 /1697

22 Орчуулах эрдэм. Дугаар 6. Улаанбаатар., 1989. 81-100.

Mong!ol sudulul-un bicig (“Papers on Mongol Studies”). № 28. Ulaanbaatar., 1982. 53-63.

23 Орчуулах эрдэм. Дугаар 4. Улаанбаатар., 1986. 82-96.

24 Хэл зохиол судлал. XX боть. II дэвтэр. Улаанбаатар., 1987. 143-151.

25 Орчуулах эрдэм. Дугаар 6. Улаанбаатар., 1989.

гавжаас Жамсраны Цэвээнд өргөсөн нэгэн төвд захианы тухайд)<sup>26</sup>, “Захиа бичгийн уран зохиол (Д.Пүрэвжавтай хамт)<sup>27</sup>, “Жалханз хутагтын төвд намтрууд, түүнд хийсэн зарим ажиглалт<sup>28</sup>, “«Нюржон-солдэв» буюу “Түргэн заларч ирэхийн залбирал<sup>29</sup>, “VI Далай ламын нууцын намтар хийгээд гүр дууллын учир<sup>30</sup> зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүддээ тухайн тухайн сурвалжаар нь нээж бичсэн байна. Улмаар «Алтан хүрдэн» хэмээх, монгол мэргэдийн төвдөөр бичсэн зохиолын цоморлогийг эмхтгэж дээр дурдсан төрөл зүйлүүдэд хамаарах гуч шахам зохиолыг хэвлүүлсэн нь хойшдын төвд хэлт уран зохиолын төрөл зүйлийн судалгаанд онцгой ач холбогдолтой бүтээл болсон юм. Мөн төвд хэлээр голчлон зохиол бүтээлээ туурвиж байсан урьд өмнө түүхийн балархай гэхээсээ, үзлийн хавцгайгаас болж төдийлөн эс дурдагдаж ирсэн, Өндөр гэгээн Занабазар, Зая бандид Лувсанпринлэй, Хамба номун хан Агванлуvsанхайдав, Эрдэнэ мэргэн бандид Агван-Ишсамбуу, ханчин хамбо Жамьянгарав, шүлэгч Лувсандондов нарын монгол мэргэдийн намтар уран бүтээлд холбогдох түүхийн, эх зохиол сурвалж судлалын олон талт судалгааг хийж тэднийг Монголын уран зохиолын гол төлөөлөгчийн хэмжээнд зохиол бүтээлийн гүн нарийн ухаан, туурвил зүйн өндөр дээд түвшингээр нь хөөн гаргаж ирсэн нь мөн л уран зохиол судлалын нэгэн үзэгдэл болсон бүтээлд тооцогддог «Огторгуйн цагаан гарди» номд нь орж хэвлэгдсэн билээ. Энэ бол уран зохиолыг ихэнхдээ зуун зуунаар тоймлон ярих төдийд авч үзэж байсан тэр цаг үеэс салгаж, бүтээж туурвиж ирсэн мэргэдийн намтар, бүтээл рүү гүнзгийрэн орж ирснээрээ Монголын эртний уран зохиол судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээл болсон юм.

Монголын уран зохиол судлалын нэг чухал асуудал бол аман бичгийн уран зохиолын харилцаа холбоо, түүгээр дамжин илэрч байгаа уран сайхны сэтгэлгээний уламжлалыг судлах явдал юм. Л.Хүрэлбаатар багш энэ чиглэлээр монголчуудын дунд амаас ам дамжин хайлж ирсэн баатарлагийн туульд эртний буддийн гүн ухааны эш номлол болсон санаанууд хэрхэн уусаж хавчуулагдаж ирснийг тодорхой баримтаар өгүүлсэн “Монгол туульс дахь буддийн аяс<sup>31</sup>, мөн төвд монгол бичгийн мэргэд ном судрын хэлнээс гадна, судрын аман хэл гэдэг нэгэн зүйл өвөрмөц орчуулгын хэлийг багшаас шавьд заан тогтоолгох замаар уламжлан авч ирсэн хийгээд, Хотгойдын жижигхэн Гомбожав өвгөнөөс сонссон “Хөгшин үнээний үг” гэдэг эртний, алдартай “үг” зохиолын судрын аман орчуулга л гэхэд өмнөх үеийн номч мэргэн гавж С.Гомбожав, М.Санждоржийн хэвлүүлсэн уламжлалт монгол бичгийн орчуулга сэлттэй хэрхэн үг утга дүйцэж байгааг жишээ сэлтээр өгүүлж, энэ нь монголчуудын судар шастирын нэгэн соёл болж уламжлагдсан тухай өгүүлсэн “Судрын аман орчуулга<sup>32</sup> зэрэг өгүүллүүдээ хэвлүүлсэн нь тэр үедээ шинэ сэргэг төдийгүй, уран зохиол судлалын нэгэн салаа мөчрийг дамжин буух учир шалтгааны ухааны өөр нэгэн сэжмийг харуулсан хэрэг болсон юм.

Улмаар зөвхөн уран зохиол гэх явцуу хүрээнд эртний их сэтгэгчдийн бүтээлийг авч үзэх нь учир дутагдалтай байгааг нөхөж, нийгэм, цаг үе, үзэл суртлын ямар нэгэн хэм хэмжүүрээс ангид, ард түмний уламжлалт соёл, гүн ухааны сэтгэлгээтэй холбон үзэж,

26 *Ил товчоо сонин. 1995 оны нэгдүгээр сарын 1-10. Дугаар 1(130).*

27 *Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies). 1. Сөүл., 2002. 273-288.*

28 *Хоёр их хутагт. (Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын тухай)”. Улаанбаатар., 1995. 9-21.*

29 *Ил товчоо. 1996 оны 7-р сарын 11-20. № 20 (204).*

30 *Буддийн судлал. Цуврал 1. Улаанбаатар., 1998. (55-86);*

*Ил товчоо сонин. 1996 оны 4-р сарын 11-20. Дугаар 11(195).*

31 *Төв Азийн тууль. Улаанбаатар., 1998. 240-263.*

32 *МУИС, МХСС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Боть XV (153). XXI дэвтэр. Улаанбаатар., 1999. 159-173.*

“Нүүдэлчний театр ба «Саран хөхөөний намтар»”<sup>33</sup>, “Буддийские мотивы в тибетском и монгольском версиях эпоса «Гесер»”<sup>34</sup>, “Гэсэрийн цам”<sup>35</sup>, “Монгол дахь Гэсэрийн шүтлэг ба Гэсэрийн цам”<sup>36</sup>, “«Нюржон-солдэв» буюу “Түргэн заларч ирэхийн залбирал””<sup>37</sup>, “«Субашидын»” жанр ба «Дөрвөн махбодын шастир»”<sup>38</sup> зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдээ хэвлүүлсэн байна.

Монгол мэргэдийн төвд хэлээр туурвин зохиосон буддийн гүн ухаан, одон орон зурхай, эм эмнэлэг, түүх, уран зохиол яруу найргийн ай савд багтах хэдэн мянган ном зохиол байгаагийн дотор, Бурханы шашны буддийн гүн ухааны хэргэм зэргийг хүртсэн, туулсан олон хутагт хувилгаадын намтар, бүтээл цагийн саалтад улирч одоод, улирч одсон тэр цагийн балархайгаас буцааж сэргээх нэрээр дахин нэртэй нэргүй хэлмэгдүүлж, төөрөгдсөн дээрээ төөрөгдөхөд хүрээд байсан 1990-ээд оны дунд үеэс Л.Хүрэлбаатар багш Монголын эртний уран зохиол судлалын нэг гол чиглэлээ тэдгээр хутагт хувилгаад бичгийн мэргэдийн намтар түүхийг судлах асуудалд хандуулж, “Жалханз хутагтын төвд намтрууд, түүнд хийсэн зарим ажиглалт”<sup>39</sup>, “Хубилай хааны улсын багш Пагба лам”<sup>40</sup>, “Хубилай хааны улсын багш Пагба ламын төр шашинд нээсэн айлдвар”<sup>41</sup>, “VI Далай ламын нууцын намтар хийгээд гүр дууллын учир”<sup>42</sup>, “Равжаа судлалын арван эндүү”<sup>43</sup>, “Ашгийн доторхи “зохиол” дүрийн гаднах “хутагт””<sup>44</sup>, “«Аварга могойн зулайн чандмань»-ийн учир”<sup>45</sup>, “«Аварга могойн зулайн чандмань» авагч хүмүүн түүнээс хамаарна”<sup>46</sup>, “Равжаагийн сургасан “гэвш Шарав” ба Нацагдоржийн бичсэн “гэвш Лодон””<sup>47</sup>, “Лувсанданзанжалцаны (1639-1704) төвд хэлээр зохиосон бүтээлүүд”<sup>48</sup>, “Бари лам Дамцагдорж ба монгол ламын эрдэм”<sup>49</sup>, “Чин сүзэгт номун хан Лувсанноровшаравын (1701-1768) төвд хэлээр зохиосон бүтээлүүд”<sup>50</sup>, “Өндөр гэгээний тухайд дахь үзлийн хэтэрхийллийг шүүмжлэх нь”<sup>51</sup>, “Бошигтын элч гэлэнд өргөсөн “Жавзандамбын залбиралаас” үүдэн өгүүлэх нь”<sup>52</sup>, “Бошигтын элч гэлэнд

33 Утга зохиол, урлаг сонин. № 23. 1990. VI. 1(1737).

34 Гесериада фольклор в современной культуре. Улан-Удэ., 1995. стр 113-121.

35 Гесериада-духовное наследие народов Центральной Азии. Международная научная конференция. Улан-Удэ., 1995. стр 70-71.

36 Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ. 4. Сөүл., 1995. 385-394.

37 Ил товчоо сонин. 1996 оны 7-р сарын 11-20. № 20 (204).

38 Монгол судлалын мэдээ. IAMS Bulletin. Улаанбаатар., 1998. 87-107.

39 Хоёр их хутагт (Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын тухай). Улаанбаатар., 1995. 9-21.

40 Монгол хэл шинжлэл (Улсын Багшийн Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг). Дугаар 1. Улаанбаатар., 1996. (21-30);

Ил товчоо сонин. 1995 оны 12-р сарын 1-10. Дугаар 34 (182).

41 Олон улсын монголч эрдэмтдийн IX их хурал илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар., 2007.

42 Буддийн судлал (МУИС. Буддийн соёлын төв). Цуврал 1. Улаанбаатар., 1998. /55-86/;

Ил товчоо сонин. 1996 оны 4-р сарын 11-20. Дугаар 11(195).

43 Билгийн толь-II. Монголын уран зохиолын дээжис LXI боть. Улаанбаатар., 1998. 198-212;

Ил товчоо. 1997 оны 1-18. 1.25. № 3/222; Суутандаа түүх хайртай. Улаанбаатар., 1998. 72-83.

44 Халхын ноён хутагт Лувсанданзанравжай судлал. Улаанбаатар., 2006. 188-197;

Ардын эрх сонин. 1998 оны 7-р сарын 23. № 171 (1950)

45 Shambhala. Дугаар 001. Улаанбаатар., 2006 он

46 Shambhala. Дугаар 001. Улаанбаатар. 2006 он.

47 Д.Нацагдоржийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл. Бээжин., 2006 оны 12 дугаар сарын 1. 146-154.

48 Ламын гэгээн Лувсанданзанжалцан (1639-1704) Эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар., 1999. 13-25.

49 Брагри ёнзин Дамцагдорже-Монголын шашин соёлын нэрт зүтгэлтэн. Улаанбаатар., 2001. 22-41.

50 Чин сүзэгт номунхан Лувсанноровшарав. Улаанбаатар., 2001.

51 Эрдэм сонин. 2005 он. Дугаар 04(84)

52 Quaestiones Mongolorum Disputatae. № 1, Executive Editors: H.Futaki, B.Oyunbilig. Association for International Studies of Mongolian Culture. Tokyo., April 30, 2005. 91-110;

Өнөөдрийн монгол сонин. 2005 оны долдугаар сарын 7. Пүрэв гараг. Дугаар 48(48);

өргөсөн “Жавзандамбын залбирлаас” үүдэж, Өндөр гэгээн, Галдан бошигт хоёрын хэрэг явдлыг мөшгөн шинжлэх нь”<sup>53</sup>, “Цэвэлванчигдоржийн төвд хэлээр бичсэн зохиолын зүйл”<sup>54</sup> зэрэг өгүүлэл илтгэлүүдээ хэвлүүлсэн юм. Энэ бүх өгүүлэл, илтгэл, шүүмж нийтлэлүүд бол Монголын Бурханы шашны хэдэн зуун дамжсан хутагт хувилгаадын намтар түүхийг шинээр сэргээх, тэдний зохиол бүтээлийг судлах, дэлгэрүүлэх, цагийн гэмээс үзлийн гэмд шилжээд алгасралын туйлд хүрчихсэн, авдраа нээгээд авдартаа байгаа алт эрдэнэсийг таньж ядан байгаа мэт эдүгээ цагийн хүмүүн биднийг мунхгийн харанхуйгаас гэтэлгэж, чухам юуг юу гэж ойлгох ёстой вэ? гэдэгт газарчилсан шинжлэх ухааны төдийгүй нийт олон түмний оюун санааны амьдралд шинэчлэлийг авч ирсэн бүтээлүүд болсон юм.

Л.Хүрэлбаатар доктор Монголын эртний уран зохиол судлалын олон арван өгүүлэл, илтгэл, шүүмж судлалын бүтээлүүдээс гадна, «Энэтхэг, Төвд, Монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо» (1987), «Сонгодог уламжлал, монгол яруу найраг» (1989), «Алтан хүрдэн» (1992), «Сайн үгсийн сан» (1995), «Монгол орчуулгын товчоон» (1995), «Огторгуйн цагаан гарди» (1996), «Бакүла ринбүчи Түвдэнчогнор» (1999), «Эсэруагийн эгшиг дуун» (1999), «Анхдугаар Богд» (2001), «Судар шастирын билиг» (2002), «Дуун, утгын яруу зохист» (2005), «Аварга могойн зулайн чандмань» (2006) зэрэг нэг сэдэвт зохиол, бие даасан судалгааны ном бүтээлүүдийг гаргасан нь хэвлэгдэн гарсан даруйдаа шинжлэх ухааны тодорхой хүрээнийхний төдийгүй, уншигч олон нийтийн анхаарлыг татаж дараа дараагийнх нь хэвлэгдэн гарах номыг сураглан хүлээдэг өөрийн уншигчидтай болсон нь уран зохиол судлал, ер монгол судлалын гүн нарийн асуудлыг зөвхөн тэр хүрээний цөөн хүн л уншиж судалдаг явцуурлаас гаргаж чадсан юм.

Тэрээр «Энэтхэг, Төвд, Монголын сургаалын яруу найргийн хэлхээ холбоо» нэг сэдэвт зохиолыг 1987 онд бичиж хэвлүүлжээ. Энэ бүтээлд «Данжуур»-аар уламжилж ирсэн Энэтхэгийн төр ёсны найман шастир хийгээд тэдгээрийн агуулга нь Бурханы шашны номлол гэхээсээ ертөнцийн явдал ёсны мөн чанарыг номлосон иргэний чиглэлийн сургаал болохыг тодорхойлж, Төвдийн хос ёсны сургаалд хэрхэн нөлөөлж Төвдийн сургаалын яруу найргийн сонгодог хэлбэр болон хөгжсөнийг Сажа бандидын «Субашид»-ын жишээн дээр өгүүлээд, улмаар хоёрдугаар бүлэгтээ Субашидын олон монгол орчуулга тус бүрийн онцлогийг дурдан, үүнээсээ Цахар гэвш Лувсанчүлтэмийн төвд хэлнээс «Субашид»-ыг орчуулсан гэх боловч чухамдаа орчуулсан биш, дуурайлган зохиосон буюу монголжуулан зохиосныг олон баримтаар үзүүлээд, цааш нь «Субашид»-ын уламжлалаар Монголд зохиогдсон Сүмбэ хамбо Ишбалжир, ноён хутагт Данзанравжаа, мэргэн бандид Агван-Ишсамбуу нарын хос ёсны сургаалуудыг харьцуулан судалж үнэлэлт дүгнэлтээ гаргасан байна. Ихэвчлэн шашны зохиол бүтээл голлож байсан мэтээр ярьж бичиж байсан Монголын дундад зууны үеийн яруу найргийн дотроос иргэний яруу найргийн хөгжлийн онцлогийг жишээ сэлтээр гарган үзүүлж, ингэхдээ эртний дорно дахины хийгээд Энэтхэг, Төвд, Монголын уран зохиолын харилцаа холбоо, Энэтхэгээс Төвдөд, Төвдөөс Монголд орчуулагдан ирсэн сургаалын яруу найргийн сонгодог хэлбэрүүд улмаар монгол яруу найргийн үндэсний сэтгэлгээний өвөрмөц шинжийг хадгалан хөгжиж ирснийг энэхүү нэг сэдэвт зохиолдоо нээн гаргасан юм. Энэ бүтээлийн талаар академич Ц.Дамдинсүрэн “Шашны сургаал зохиол ноёрхсон оронд иргэний зохиолын хувь заяа ямар байсан тухай утга зохиолын онолын асуудлыг шийдвэрлэхэд Хүрэлбаатарын энэ судлал нь нэмэр хандив болох ёстой... «Субашид» бол чухамдаа зөвхөн орчуулга биш, «Субашид»-ыг дуурайлган зохиосон монгол зохиол болсон өвөрмөц байдлыг олон баримтаар гаргаж нотолсон нь гагцхүү зэрэг горилогч

*Зууны мэдээ сонин. 2005.7.7. Дугаар 162(1985).*

53 *Эрдэм сонин. 2006 он. Дугаар 03(95).*

54 *Эрдэм сонин. 2006 он. Дугаар 05 (97).*

Л.Хүрэлбаатарын гавьяа болно<sup>55</sup> хэмээн үнэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Энэтхэг, Төвдийн сургаалын яруу найргийн сонгодог бүтээлийг зөвхөн наашаа Монголын хэлэнд орчуулаад зогсоогүй, түүний уламжлалыг монгол яруу найргийн хөрс сууринд идээшүүлэн, Монголын хос ёсны сургаалын өвөрмөц нэгэн төрөл улам баяжин хөгжих таатай боломж болсон юм гэдгийг энэхүү судалгааны бүтээл харуулжээ. Тийм учраас Оросын санскритч, монголч эрдэмтэн С.Д.Серебряный, Ю.Н.Неклюдов нар “Энэтхэг, Төвдөөс уламжлалтай Монголын сургаалын яруу найраг” нэрээр “Төв Ази, Алс дорнодын уран зохиолын төрөл зүйл ба найруулга” номд хэвлүүлж, мөн 1987 онд уг бүтээлийн товчийг «Орчин үеийн монгол судлалын тулгамдсан асуудал»<sup>56</sup> олон улсын монголч эрдэмтдийн хурлын эмхтгэлд орос хэлээр тус тус хэвлүүлэн олны хүртээл болгосон билээ.

Л.Хүрэлбаатар багш монгол яруу найргийн уламжлал шинэчлэлийг XIII-XX зууны дунд үе хүртэлх яруу найргийн сонгодог бүтээлүүдийн жишээн дээр өгүүлсэн «Сонгодог уламжлал, монгол яруу найраг» номыг 1989 онд хэвлүүлсэн юм. “Монгол яруу найргийн төрөл зүйлийн уламжлал” хэмээх эхний бүлэгт сургаалын, магтаалын, дууллын гэсэн гурван төрлөөр Энэтхэг, Төвд, Монголын яруу найргийн эртний уламжлалт бүтээлүүдийг дурдаад түүнээсээ нарийсган, Монголын яруу найрагт энэ гурван төрөл хэрхэн хөгжиж ирснийг өгүүлжээ. Энд “Сургаалын шүлэг” дэд бүлэгт XIII-XIV зууны “Гурван зуун тайчуудыг дарсан домог”, “Оюунтүлхүүр”, “Чингисийн билиг” сургаалаас эхлээд Зая бандид Лувсанпринлэйн “Алтан хатгуур тэргүүтэн өвөр бусдад зөвлөсөн сургаал”, Хөхнуурын Ишбалжирын “Хүний ёсны шастир цэцгийн үзэсгэлэнт эрих”, Агвандандарын “Хүний номын баяр хурим”, Ишданзанванжилын “Галын шастир хос ёсны зуун халуун гэрэлт”, Шагдарын “Номын ба ертөнцийн хоёр ёсны сургаал саруул оюуныг баясагач”, Зава Дамдин гавжийн “Зүрхний үг талхлан тээрэмдэгч хурд”, Данзанравжаагийн сургаалууд, мөн шинэ үеийн яруу найргийн төлөөлөл болгож, Ц.Дамдинсүрэн, Б.Явуухулан, Ш.Сүрэнжавын шүлэг найраглалын сургаалын чанарыг уламжлал шинэчлэлийн харьцаанд нь авч үзсэн байна. Харин “Дууллын шүлэг” дэд бүлэгт Энэтхэгийн «Наян дөрвөн шидтэний намтар» дахь дууллын шүлгүүд хийгээд Төвдийн Миларайбын «Буман дуулал» тэргүүтний уламжлалаар монгол яруу найраг дахь Ишбалжир, Найман тойн Дондовжалцан, Агванцүлтэмжамц, Агвандамба, Лувсанцүлтэм, Агванхайдав, Агвантүвдэн, Лувсанноровшарав, Данзанравжаа тэргүүтний дууллын шүлгүүдийн зохиомж хэлбэр, агуулга, гүн ухааны сэтгэлгээний уламжлал хөгжин дэлгэрэхдээ шинэ үеийн яруу найрагт хэрхэн нөлөөлж ирснийг Б.Явуухулан, Д.Пүрэвдорж, М.Цэдэндорж, Ж.Бадраа, Ш.Сүрэнжав, Б.Лхагвасүрэн нарын бүтээлээр жишээ аван өгүүлсэн байна. “Магтаалын шүлэг” дэд бүлэгт монгол ардын дунд дэлгэрсэн “Алтай хангайн магтаал”, “Таван хошуу малын магтаал”, “Арван хоёр жилийн магтаал” зэрэг ардын аман билгээс үүдэлтэй магтаалын яруу найраг бичгийн уран зохиолд XIV зууны их бичгийн хүн Чойжи-Одсэрийн “Махагалын магтаал”, арай хожуу үеийн Агван-Ишсамбуугийн “Тойсомжамцын магтаал наран саран чимэг”, Агванданзанямын “Мөнх бусын магтаал магад гарахын наран ургахын өмнөх үүрийн шаргал гэгээ”, Шадивдандарын “Магад гарахын магтаал үзэгдэл гэгээний хувийг таслах алтан хяргуур”, Зава Дамдины “Энэрэн нигүүлсэхүй сэтгэлийн магтаал”, Агванбалдангийн “Бодь сэтгэлийн магтаал” зэрэг бичгийн уран зохиолд төвд монгол хэлээр дэлгэрснийг мөн орчин үеийн эх орон уул усны магтаал зонхилсон иргэний уянгын яруу найрагтай холбон өгүүлсэн байна. Эндээс аман бичгийн уламжлалтай магтаалын яруу найрагас уламжлан эртний бичгийн

55 1983 онд Л.Хүрэлбаатарын «Энэтхэг, Төвд, Монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо» Хэлбичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг гориж бичсэн ганц сэдэвт зохиолд өгсөн удирдагч багш Ц.Дамдинсүрэнгийн санал. –Л.Хүрэлбаатар багшийн хувийн архивт буй бичмэл эхээс авав.

56 *Связи индийской, тибетской и монгольской дидактической поэзии. –«Актуальные проблемы современного монголоведения». Уланбатор., 1987.*

уран зохиолд бурхдын магтаалын тогтсон хэлбэр бий болж тэр нь хожмын уул ус, орон хийдийн магтаал сэлтэд хэрхэн уламжилж, улмаар агуулга үзэл санаа, уран дүрслэлийн хувьд хэрхэн хувьсаж өөрчлөгдсөнийг уламжлал шинэчлэлийн харьцаанд нь авч үзсэн байна “Монгол яруу найргийн сэдвийн уламжлал, шинэчлэл” гэсэн хоёрдугаар бүлэгт хүслийн тухай, байгалийн тухай, эхийн тухай гэсэн гурван сэдвийн хүрээнд эрт эдүгээгийн монгол яруу найргийн уламжлал шинэчлэлийг авч үзэхдээ мөн Энэтхэг, Төвдийн хийгээд уламжлалт дорно дахины уран сайхны сэтгэлгээний нийтлэг хэв маяг, монгол яруу найргийн сэтгэлгээний өвөрмөц онцлогийг нөхцөлдүүлэн авч үзсэн нь энэхүү онол туурвил зүйн суурь судалгааны бүтээлийн шинэлэг тал болсон юм.

Мөн XIII-XX зууны эхэн үе хүртэлх монгол мэргэдийн олон зуун жилийн туршид бүтээж ирсэн орчуулгын өв уламжлалыг тоймлон өгүүлсэн «Монгол орчуулгын товчоон» ном нь 1995 онд хэвлэгдэн гарсан юм. YII-YIII зууны үеэс Энэтхэгийн «Трипитакагийн» алдарт цоморлогуудыг согд, уйгур хэлнээс орчуулж байсан, улмаар XIII-XIV зууны үед уйгур, перс, араб, хятад, төвд, санскрит хэлнээс төрөл бүрийн эрдэм ухааны зохиолыг эх хэлнээ орчуулж байсан, тэр үеийн бичгийн их хүн хоёр хэлийг өгүүлэгч Чойжи-Одсэр бандида Энэтхэгийн гүн ухааны яруу найраг «Бодичарияавадара»-г санскрит хэлнээс орчуулсан, Төвдийн иргэний яруу найргийн алдарт цоморлог «Субашид»-ыг Сономгара тэргүүтэн төвд хэлнээс орчуулж байсан, мөн Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн, орчуулагч Бортөмөр, Алинтөмөр нар «Ачлалт ном» зэрэг төр иргэний олон шастир сургаалыг хятад хэлнээс орчуулж байсан, Уйгурын эрдэмтэн Цилона-даши (Цзя-лу-на-да-сы), Брадирашири, Карунадас нар санскрит, төвд судар шастирыг уйгур хэлнээс орчуулж байсан, Энэтхэгийн «Трипитакагийн» алдарт цоморлог болох «Ганжур», «Данжур»-ын дотор орсон 5000 гаруй ном бүтээлийг орчуулах, хэвлэх уламжлал тогтож ирсэн гээд монголчуудын орчуулгын арвин их өв уламжлалыг нэхэн өгүүлжээ. “XIII-XIV зууны үеийн орчуулгын зохиол”, “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол”, “XVII-XVIII зууны үеийн орчуулгын зохиол”, “XIX-XX зууны эхэн үеийн орчуулгын зохиол” гэсэн дөрвөн бүлгээр хуваан, бүлэг бүрийн эхэнд тухайн зуунд дорно дахины ямар ямар хэлнээс ямар алдартай дурсгалуудыг орчуулсан тухай тоймлоод улмаар, Чойжи-Одсэр, Шаравсэнгэ, Зая бандид Намхайжамц, Гүүш цорж, Дай гүүш Агвандампил, цахар гэвш Лувсанцүлтэм, Сумадирадна буюу Лувсанринчин нарын XIII-XX зууны эхэн үе хүртэлх, ихэвчлэн төвд хэлнээс ном зохиол орчуулж байсан монгол мэргэдийн орчуулгын зохиолыг тусгайлан авч тоймлосон нь Монголын орчуулгын зохиолын өв уламжлал, Энэтхэг, Төвд, Монголын уран зохиолын харилцаа холбооны хөгжлийн зүй тогтлыг харуулах суурь судалгааны бүтээл болжээ.

Л.Хүрэлбаатар багшийн Монголын эртний уран зохиолын эх бичиг сурвалж судлалын нэг гол бүтээл болох «Сайн үгсийн сан» хэмээх Монголын эртний уран зохиолын дээж бичиг 1995 онд хэвлэгдэн гарсан бөгөөд энэ нь 1959 оны Ц.Дамдинсүрэнгийн «Монгол уран зохиолын дээжис зуун билиг оршвой» эмхтгэлийг залгамжилж гарч ирсэн баяжмал шинэ судрын чуулган юм. Уг эмхтгэлд Монголын бичгийн уран зохиолын түүхэнд зөвхөн уугуул монгол хэлний төдийгүй, төвд, хятад хэл дээрх монгол мэргэдийн зохиолын хоёр бүлгийг нэмж, цаг хугацааны хувьд XIII зуунаас XX зууны эхэн үе хүртэлх гол төлөөлөгчдийг хамруулсан бөгөөд уран зохиолын цөөн төрлөөс цааш нь, домог, цадиг, түүх, намтар, эрих товчоон, тууж, шастир, үг, захиа бичиг, өчиг тангараг, санагалзал, харуусал, гэрээс зарлиг, тахил төгсгөл, ерөөл магтаал, сургаал, дууллын шүлэг гээд уламжлалт олон төрөл зүйлээр дэлгэрүүлж, ингэхдээ гол төлөөлөгчийн хувьд зуун зууны нэр бүхий цөөн хүний уран бүтээлд эргэлддэг байсныг ахиулж, төвд, хятад хэлээр зохиолоо бичдэг, урьд өмнө судалгаа шинжилгээний төвшинд төдийлөн эс дурдагдаж байсан авч ард түмний дунд зохиол бүтээл нь амаар болон бичгээр тархаж үлдсэн 50 гаруй төлөөлөгчийн бүтээлийг шинээр оруулж,

тэр бүхний сурвалжийг эрж хайж, цуглуулж, нээн шинжилж, орчуулан буулгаж, нэмэлт тайлбар, хавсралт лавламжийг нэг бүрчлэн үйлдэж гаргасан байна. Эдгээр нээлтийн чанартай олон шинэлэг зүйлийг агуулснаараа «Сайн үгсийн сан» нь Монголын эртний уран зохиолын эх бичиг сурвалж судлалыг хэлний, төрөл зүйлийн, гол төлөөлөгчдийн түвшинд урагш ахиулж чадсан шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой бүтээл болсон юм.

Монголын утга соёлын түүхэнд сүүлийн гурван зууныг дамнан гарч ирсэн номын мэргэд, бурхны шашны нэрт зүтгэлтэн, буддийн гүн ухаантан, орчуулагч, яруу найрагч соён гэгээрүүлэгч нийт арван мэргэдийн намтрыг түүхэн хөрөг маягаар бичсэн «Огторгуйн цагаан гарди» номоо 1996 онд хэвлүүлж, үүнд Өндөр гэгээн Занабазар, Зая бандид Лувсанпринлэй, Хамбо номун хан Агванхайдав, Ханчин хамбо Жамьянгарав, Эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу, Ноён хутагт Данзанравжаа, Цанид ловон Шагдар, Жалханз хутагт Дамдинбазар нарын намтар түүх, төвд хэлээр зохиосон ном бүтээлийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Энэ нь монгол мэргэдийн ихэвчлэн төвд хэлээр бичсэн ном бүтээлийг олж цуглуулах, эх бичгийн түвшинд нягтлах, орчуулах, үг утгын тайлбар, уран зохиолын онол туурвил зүйн задлан шинжилгээ хийх, улмаар утга зохиол, соёл түүхийн ямар үнэ цэнэтэй бүтээл болохын учир холбогдлыг нээх, зохиол бүтээлээр нь дамжуулан тэдний намтар түүхийн улирч одсон бүдэг жимийг нэхэн гаргах судалгаа шинжилгээний бүхэл бүтэн цогц бүтээл болсон юм. Ингэхдээ эдгээр хутагт хувилгаадын намтар түүхийн судалгаанд ээдрээтэй маргаантай байсан олон асуудлыг нэгэн мөр болгосон бөгөөд жишээлбэл, Өндөр гэгээний өнгөрсөн түүхийн үнэлгээг няцаахад бүрэн хангалттай төвд сурвалжийн баримтуудыг шинээр гаргаж, Ноён хутагтын зохиол бүтээлийг улааны шашны эш үзэлт, буддийн шашных нь урлаг гоо зүйн оньс түлхүүрээр эш хийн, эдүгээчилсэн, хэвшсэн олон тайлбар ойлголтыг огт өөрөөр задлан шинжилсэн бөгөөд ханчин хамбо Жамьянгаравын төвд хэлээр бичсэн утга зохиолын онолыг Энэтхэгийн «Зохист аялгууны толь»-ийн орчуулга тайлбар төдий биш, дорно дахины яруу найргийн онолын нийтлэг сэтгэлгээний хэв маяг дээр тулгуурлан Монголын яруу найргийн сэтгэлгээний өвөрмөц онцлогийг тусган, монгол яруу найргийн бие даасан онолын бүтээл болтол хөгжүүлж чадсан байна гэдгийг баталжээ. Уг бүтээлийн талаар Б.Ширэндэв "...Монголын уран зохиолын "Орхигдсон бүлэг" болсон төвд хэлт зохиолчдын бүтээлийг нарийсган судалсан нь манай уран зохиол судлалын цагаан зай болон үлдсэн асуудлыг нухацтай хөндсөн хэрэг юм. Ингэж мэдэгдээгүй байсан юмыг нөхөж өгснөөрөө XXI зуунд манай уран зохиолыг урагш нь хөгжүүлж байгаа юм гэж үзэх бүрэн үндэстэй болой"<sup>57</sup>, Ш.Барайшир "...Доктор Л.Хүрэлбаатарын «Огторгуйн цагаан гарди» зэрэг тансаг сайхан найруулгатай бүтээл гарч байгааг бахархан тэмдэглэлтэй"<sup>58</sup>, С.Байгалсайхан "...«Огторгуйн цагаан гарди» хэмээх бүтээл дундад зууны үеийн монголчуудын урлаг соёлын өвийг зөвхөн орчуулан, тайлбарлан хэвлэж байсан өмнөх бүтээлүүдээсээ, номч мэргэдийг зохиол бүтээлээр нь дамжуулан сав шим ертөнцийг хэрхэн ойлгож таньж мэдэж байсан, түүнийгээ ямар хэлбэрээр яаж илэрхийлж байсан тухай дэлгэрэнгүй задлан үзсэн судалгааны зохиол болсноороо ялгарч байгаа юм"<sup>59</sup>, түүхч И.Цоодол "Зохиогч бүтээлдээ Өндөр гэгээн Занабазараас Монголын соёл урлагийн хөгжилд оруулсан их хувь нэмрийг үзүүлэхдээ түүний улс төр нийгмийн үзэл баримтлал, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар ...гүнзгий хөнджээ. Юуны өмнө зарим хүмүүсийн ярьж бичиж байгаагаар Занабазар улс үндэстнээсээ урваж, эх орноо худалдсан мэтээр өнөөгийн хойч үеийнхэнд ойлгуулж байгааг нь сэтгэл эмзэглэн няцаасантай нь

57 Б.Ширэндэв. Номоос үүдэн өгүүлэхүй. -«Утга зохиол урлаг» сонин. 1996.6.16 №10

58 Ш.Барайшир. Эх хэлээ зэрэмдэглэж дуусах нь ээ. - "Засгийн газрын мэдээ" сонин. 1994 оны 4-р сарын 4. Дугаар 27(173))

59 С.Байгалсайхан. Оюун далайн сувдыг тольдон шинэ цагийн егчаан туурвигч.- – "Билгүүн судар" сонин. 1996 оны есдүгээр сарын 24. Дугаар 23(33))



миний хувьд санал нийлж байна<sup>60</sup>” гэх зэргээр үнэлсэн байна.

Улмаар «Огторгуйн цагаан гарди-I»-ийн үргэлжлэл, мөн XIII-XX зууныг хүртэлх, Монголын бичгийн их мэргэдийн намтар түүхийн 10 хөргийг багтаасан «Огторгуйн цагаан гарди-II» номоо 2008 онд хэвлүүлсэн юм. Өөрийн номын багш, их эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулж өргөн барьсан энэ бүтээлд “Долоон зууны чинад дахь түүхийн хөлгийн тоос” (Пагва лам Лодойжалцан (1235-1280)), “Амьдаа суух олбоггүй, ажирсан хойноо шүтэгдээгүй газаргүй” (VI Далай лам Цаньянжамц (1683-1746)), ““Мөнх, мөнх” хэмээвч мөнх нь үгүй огторгуйн солонго” (Ламын гэгээн Лувсанданзанжалцан (1639-1704)), “Өндгөн дотроо жиргэн донгодох Галабингын эгшиг” (Чин сүзэгт номун хан Лувсанноровшарав (1701-1768)), “Сэтгэлийн далайд эрдмийн лянхуаг дэлгэрүүлэгч” (Вангай равжамба Агван-Иштүвдэн (XVIII-XIX зуун)), “Хоёр дүрийн Богдын номын ёнзин багш” (Бари лам Дамцагдорж (1781-1848)), “Монгол нүүдэлчдийн их сударч” (Эрдэнэ бишрэлт мэргэн бандид Цэвэлванчигдорж (1836-1894)), “Их Монголын түүхийн тэргэн замыг заагч” (Зава лам Лувсандамдин (1867-1937)), “Халх газрын хамгийн сүүлчийн номч хутагт” (Дарба бандид Агванчойнжирдондов (1870-1927)), “Дорно цастын мөнгөн суварга” (Халхын Сэнгээ гэвш (1905-1993)) гэсэн сүүлийн найман зууныг дамнасан 10 их мэргэдийн намтар түүх, тэдний Монголын Бурханы шашин, буддийн гүн ухаан, түүх, утга соёлын хөгжилд оруулсан хувь нэмрийг бүтээл номоор нь дамжуулан гаргасан гайхамшигт бүтээл болсон юм. «Огторгуйн цагаан гарди»-ийн учрыг тайлж Л.Хүрэлбаатар “Энэ бүх номын мэргэдийн зохионгуй үйлс бол эцэст бүгд л сэтгэлийн хирийг арилгах, оюуны гэгээнийг нээх нэгэн санаа савын учир зорилгод нэгдэхийн тул, тэр бүх мэргэдийг цөмийг нь мөнхдөх тасархайтахын халил ганга, хаягдах цээлд унан егүүдэхийн гэм уналаас хагацсан, хоосонхүүн номын агаарын, “Огторгуйн цагаан гардийн сүрэг” хэмээн ухаж, дээр огторгуйн дэлгэмэр цагаан гардийн дэвэлт нисэлтийн араас дуурайн дагаж нисэхийг санавч, доор газрын өчүүхэн жаахан эгэл бэртэгчний бор богширго өд сөдөө дэмий хөдөлгөн, өөдөө дээшээ ангайн гайхаж хоцорном билээ. Иймд эл номыг «Огторгуйн цагаан гарди» хэмээн нэрлэсний учир утга ч энэ билээ”<sup>61</sup> хэмээн өгүүлсэн байдаг.

Эрдэнэ мэргэн бандид Жамьянгаравын яруу үгийн онолд шинжлэл хийсэн, монгол яруу найргийн онолын суурь судалгааны бүтээл «Эсэруагийн эгшиг дуун» номоо тэрээр 1999 онд хэвлүүлсэн юм. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Ардын аман зохиол ховор ном судлах шинжилгээний анги 1976 онд Архангай аймагт ажиллах үеэр олж ирсэн, С.Жамьянгаравын төвд хэлээр, буддийн гүн ухааны марган хэлэлцэх аргаар бичиж, барлагдан дэлгэрч байсан 600 нүүр судрыг Л.Хүрэлбаатар багш тусгайлан судалж, анх удаа монгол хэлнээ орчуулаад, орчуулснаа судлан боловсруулаад, бусад Энэтхэг, Төвд, Монголын номын мэргэдийн үе үед бүтээсэн алдартай төвд тайлбаруудтай харьцуулан шинжлээд, онол туурвил зүйн онцлогийг нь даруй таван бүлгээр багцлан судалгааны олон нийтэд хүргэсэн нь эх сурвалжийн хувьд нэн шинэ зүйл болжээ. Нэн шинэ гэдгийн учир нь, Монголын эртний үе үеийн дуун ухаантан зохист аялгууч нар Энэтхэгийн Дандийн «Зохист аялгууны толь» хэмээх онолын бүтээлийг орчуулах тайлбарлах, жишээ шүлгийг төвд монгол хэлээр зохион бичих ажлыг өөр өөрийн түвшинд хийж ирсэн бөгөөд тэдгээрийн дотроос эрдэнэ мэргэн бандид ханчин хамбо Жамьянгаравын энэ бүтээл бол зөвхөн Энэтхэгийн тэр яруу үгийн онолын тайлбар төдий биш, түүн дээр уламжлал аваад монгол үндэсний яруу найргийн сэтгэлгээний өвөрмөц онцлог, түгээмэл зүй тогтлыг тусгасан бие даасан онолын бүтээл болтол хөгжүүлж чадсан байна гэдгийг Л.Хүрэлбаатар багшийн судалгаа баталж чадсан

60 И.Цоодол. Түүхийг алагчилбал түмнийг төөрүүлдэг. – “Засгийн газрын мэдээ” сонин. 1994 оны 8-р сарын 26. Дугаар 64(210))

61 Л.Хүрэлбаатар. Огторгуйн цагаан гарди II. Улаанбаатар., 2008.8.

явдал юм. Ийм учраас Энэтхэгийн монголч эрдэмтэн Локеш Чандра Л.Хүрэлбаатарын бичсэн “Дандийн Зохист аялгууны толь ба түүний тайлбарууд” хэмээх бүтээлийг англи хэлээр Энэтхэгийн «Төвд» хэмээх сэтгүүлд нийтлүүлж, тэрчлэн гадаад дотоодын олон эрдэмтэд уг судалгааны ажлын шинжлэх ухааны үнэ цэнийг бахдан өгүүлсэн байдаг юм. Жишээлбэл, академич Д.Цэрэнсодном “Энэ бол уламжлал шинэчлэлийн залгамж холбоо шинжлэх ухаанд хичнээн ач тустай болохыг гэрчилж буй нэгэн баримт юм<sup>62</sup>”, Оросын эрдэмтэн хэл шинжлэлийн ухааны доктор, профессор В.Ц.Найдаков, түүхийн ухааны доктор, профессор Ц.П.Ванчикова нар “Л.Хүрэлбаатар дундад зууны үеийн Төв Азийн соёл дахь буддийн утга зохиолын жаяг дэг нь ямар ч хөдөлгөөн хөгжилгүй зүйл бус, харин алгуур аажмаар уран сайхны шинэ сэтгэлгээгээр хувьсан хөгжиж, баяжин гүнзгийрч ирсэн хууль зүйтэй болохыг нээн шинжилж гаргасан байна. Энэхүү гол үзэл баримтлал нь онолын үүднээс нэн их сониролтой байна”, Оросын монголч эрдэмтэн К.Н.Яцковская, “Л.Хүрэлбаатар бол хэдийн Монголыг судлагчдын дотор нэр өндөр болсон, Монголын төвд хэлт утга зохиолын нарийн мэргэшсэн эрдэмтэн юм. Түүний урьд өмнө нийтлүүлсэн бүтээл бүхэн тодорхой нарийн мэдлэгээрээ, дэвшүүлсэн асуудлын итгэмжит чанараараа, өөгүй нягт шинжилгээгээрээ эрс ялгарч байдаг. Зохиогч, Жамьянгаравын бүтээлийн утга санаа руу, Жамьянгаравын тайлбарын зохиол руу, Жамьянгаравын өвөрмөц сонин хууль зүйтэй уран сайхны сэтгэлгээний тогтолцоо руу, яруу найргийн онол руу чөлөөтэй нэвтрэн орж чадсан байна”, Өвөрмонголын Их Сургуулийн профессор Б.Гэрэлт “Монголчуудын төвд зохиолын түүхэн хөгжлийн өргөн дэвсгэр дээр Жамьянгаравын онол судалгааны содон бүтээлийг тусгайлан авч, шинжлэх ухааны задлал хийсэн явдал монгол судлалын хүрээ хявцаанд анх гарч байгаа үзэгдэл юм” гэх зэргээр тус тус үнэлж дүгнэсэн нь дорно дахины яруу үгийн онолын сэтгэлгээний суурин дээр үндэслэсэн, Монголын их онолчийн бүтээлийг шинжлэх ухааны эргэлтэнд оруулж, судалгаа шинжилгээний зохих байр суурийг эзлүүлж чадсан, Л.Хүрэлбаатар багшийн эрдэм судлалын нэгэн оргил бүтээл болжээ гэдгийг давхар нотолсон хэрэг юм.

Мөн 1999 онд тэрээр «Бакүла ринбүчи Лувсантүвдэнчогнор» хэмээх номоо туурвиж, Арилсан хутагтын орны номын их багш Бакүла ринбүчийн намтар, шашин төрийн үйл хэрэгт хүчин зүтгэсэн он жилийн түүхийг сөхөн өгүүлж, ингэхдээ Энэтхэг газрын арван зургаан архадаас Күшок Бакүла болж, Энэтхэг, Төвдийн газар салаалсан өмнөх арван найман дүртэй нь холбож, улмаар номын их эрхшээлт Ладагийн газар “жасрай” буюу “жалсрай” хэмээх хан хөвгүүн болж мэндэлснээс эдүгээгийн наяд илүү сүүдрийг зооглоод байгаа он цагийг хамруулан хөөж бичсэн юм. Судлаач эл номыг бичихийн тулд Бакүла ринбүчи багштаны өөрийн мутраар, төвд хэлээр бичсэн “Бундарига цэцгийн эрих” хэмээх товч намтар, мөн төвдөөр бичсэн айлдвар, сургаал зарлиг зохиол, тэмдэглэл, дурсамж, монгол газар ирээд айлдсан зарлиг сүнчойн зүйлсийг Гандантэгчинлин хийдийн номч хувраг Гүндсамбуугийн дуу хураагуураас буулгаж орчуулсан нэгэн зүйл бичиг, түүний урьд дүрүүдийн намтар цадиг, залбирал ерөөл, Бакүла тэргүүтэн арван зургаан архадын тухай Энэтхэг, Төвд, Монголын мэргэдийн төвд хэлээр бичсэн зохиол, тайлбар, тэмдэглэл мөн Бакүла ринбүчи багштаны тухайд Төвдийн Банчин эрдэнэ, Далай лам, Тизин ринбүчи, Сажа ринбүчи, Раграй ринбүчи, Энэтхэгийн Дармабала Махатера нарын хэлсэн үг, илгээсэн захиа бичгийн зүйлс, мөн Бакүла ринбүчийн дэргэдийн шадар явсан ладагба Түвдэндаржаа, нарийн бичгийн дарга Сономванчиг нарын дурсамж яриа сэлтийг үндэслэж, номын нэгдүгээр бүлэгт арилсан хутагтын орон хэмээх Энэтхэг орны тухай, Энэтхэг, Монголын улс төр, соёлын харилцаа, тэр газар алдаршсан номын их түүчээ нарын тухай гурван дэд бүлгээр өгүүлээд, номын хоёрдугаар бүлэгтээ Энэтхэгийн арван зургаан архад, Бакүла ринбүчийн арван найман

62 Л.Хүрэлбаатарын «Эсэраугийн эгшиг дуун» номын удиртгалд ийн өгүүлжээ.

дүрийн намтар түүх, Бакүла ринбүчийн Ари Ладагийн газар Нанва-таяа хааны өргөө гэрт мэндэлсэн тэр цагаас эхлээд гурван сүүдэртэйд нь хувилгаан тодруулж, таван сүүдэртэйд нь ширээнд залснаас хойших Энэтхэг, Төвд, Монголын газар шашин төрийн хос ёсны үзэл санааг төр, нийгмийн амьдралд хэвшүүлэн суулгах тухайд бие сэтгэлийн алжаалчилуурийг умартан хүчин зүтгэсэн ная илүү жилийн нь түүхийг дэлгэн өгүүлсэн байна. Зохиолын гуравдугаар бүлэгт Монголын номын мэргэд хутагт хувилгаадын шашин төрийн үзэлт хийгээд эрт эдүгээг түүчээлэн холбож ирсэн Бакүла ринбүүчийн Бурханы шашны хийгээд төр шашны үзэл баримтлалын талаар холбон өгүүлсэн бөгөөд энэхүү ном бүхэлдээ номт гурван улсын шашин төр, нийгэм, соёлын харилцааны уялдаа холбоо уламжлал, эрт эдүгээгийн явдал ёсны учрыг нэгэн их багш Бакүла ринбүчийн намтар түүхээр шалтаглан өгүүлсэн томоохон судалгааны бүтээл болсон юм.

Эрдэмтэн Л.Хүрэлбаатар Өндөр гэгээн Занабазарын намтар, уран бүтээлийн судалгааг олон жил хийж «Анхдугаар богд» номыг 2001 онд «Монголын зуун хаан, найман Богд» цувралаар хэвлүүлсэн юм. “Өндөр гэгээнийг судалсан гэх эрдэмтэд, бичсэн хэмээх зохиолч сэтгүүлчдийн бүтээл туурвилд намтрын нь түүхэн үнэнээр гэрч шалгуур хийж үзэхэд худал хуумгай, эндүү ташаа, осол цалгай олон зүйл гарч, түүний нь цааш бас “эш гэрчид” авч, “үнэн баримтад үзэж”, алдаанаас нь алдаа хүүлсээр, буруу мэдлэг мэдээллийн урт жингийн зам хэдэн үеийн мэдлэгийн аяныхныг газарчлах”<sup>63</sup> болсон тэр цагт Өндөр гэгээний төвд, монгол хэлээр бичигдсэн арав гаруй намтар цадигт тулгуурлан, гадаад дотоодын олон нөхдийн бичсэн эндүү ташааг нэгбүрий эш баримтаар мөшгөж, Жавзандамбын хувилгааны олон билэг чанарыг үзүүлэн төрсөн хийгээд, гурван сүүдэртэйгээс Ламадан тэргүүтэн Ганданлхавжа, Жамбалцанжид, Маани, Базарваань тэргүүтнийг өөрөө аяндаа уншиж олон билэг чанарыг үзүүлсэн тул Халхын газар мэргэн тойн Жамбалин номунхан бээр үснирийг авч гэнэн санваарыг өргөөд Төвдийн хэлээр Ишдорж, Монголын хэлээр Бэлгэ билгийн очир, Энэтхэгийн хэлээр Занабазар хэмээн соёрхон зохиосон тэр цагаас Монголын түүхэнд сүүлийн гурван зуун жилд болж өнгөрсөн төр шашны олон асуудал Өндөр гэгээний намтар түүхэнд холбогдож, “ял гавьяа хоёрын сөргөлдсөн хоёр утга, аврагч урвагчийн ташимгай хоёр үзэлт ихэрлэн сүлжилдсээр өнөөг хүрч”<sup>64</sup> ирсний утгыг хөөн хэлэлцжээ.

«Судар шастирын билиг» хэмээх 2002 онд хэвлэгдсэн энэхүү бүтээлд, төвд, монгол мэргэдийн төвд хэлээр туурвисан буддизмийн утга зохиол, их бага ухаануудын гол гол судар шастирууд хэрхэн монгол нүүдэлчдийн ном соёл болж боловсорсныг “Мунхгийн нойрноос сэрээх номын цагаан дунгийн дуун”, “Судар шастирын монгол уламжлал”, “Шастирын аймгийн монгол уламжлал”, “Судрын аймгийн монгол уламжлал”, “Залбирал шүлэг захиа бичгийн монгол уламжлал”, “Соёлын мянган сүлжээ-эвийн өлзий утас” гэсэн 6 бүлгээр хуваан өгүүлээд судлан шинжилж, задлан тайлбарласны дотор “Тогтсон тааллын шастир”, “Хөгжмийн шастир”, “Цамын шастир”, “Эш бошгийн судар”, “Ёр бэлгийн судар”, “Газрын шинжийн судар”, “Зүүдний шинжийн судар” зэргийг оруулж эдгээр зүйлс монгол нүүдэлчдийн зан сэтгэлгээнд хэрхэн уламжилж ирсэн хийгээд үүнийг танин мэдсэнээр бид монгол үндэсний өвөрмөц сэтгэлгээний хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх, улмаар урлаг уран зохиол, гоо зүй шашин суртахуун, гүн ухаан, соёлын судалгаа шинжилгээг ийм олон талт суурь ухааны мэдлэггүйгээр шинжлэн судлах боломжгүй юм гэдгийг давхар харуулсан юм. Ийм учраас филисофич доктор, профессор Н.Хавх уг номын өмнөх үгэнд “судалгааны олон нийт төдийгүй, уншигч олны сонирхол анхаарлыг татсан шинэлэг, шинжлэх ухааны ихээхэн ач холбогдолтой ном болжээ”<sup>65</sup> хэмээн гэмдэглэсэн байна.

Монголын утга зохиолыг аман бичгийн соёлын хөрс суурь, дорно дахины сэтгэлгээний уламжлал дээр задлан шинжилж, монгол хүний уран сайхны сэтгэлгээний өвөрмөц болон нийтлэг шинжийг нэгтгэн дуун, утгыг хэрхэн яруу зохистод туурвидаг аргыг соёл

иргэншлийнх нь орчин, үндэсний төрхөөр нь тодорхойлсон «Дуун, утгын яруу зохист» ном 2005 онд хэвлэгдэн гарчээ. Энэ тухай доктор Л.Түдэв бичихдээ “Л.Хүрэлбаатар монгол уран зохиолын навч мод бутыг чухамхүү урган төлжиж буй монгол хөрснөөс нь, шим гэжээл авч буй монгол ардын суу билгийн далайгаас нь, дорно дахины уран сэтгэлгээний хурын уснаас нь гарваль зүйг нь эрэн хайж, олж шинжих арга ухаанаар “ном шинжих” зарчим журмыг тунхагласан байна. Иймээс Монголынхоо бүтээлийг монгол нүдээрээ харж шинжихэд яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол алинд нь ч үндэсний уламжлал, үндэсний ахуй, үндэсний сэтгэл шингээстэйг номынхоо хуудас бүрт нотлон харуулжээ”<sup>64</sup> гэж үнэлсэн байна. “Монгол аман билиг”, “Дуун, утгын яруу зохист”, “Ламыг номоор нь нээж, хутагтыг ёсоор нь үзүүлэхийн учир” хэмээх гурван бүлэгт хотгойд, дархад, халх аман билиг, аман яруу найраг, Б.Явуухулан, Д.Пүрэвдорж, Ж.Бадраа нарын яруу найраг, Д.Цэдэвийн тууж, өгүүлэгийг туурвил зүйн задлан шинжлэл хийж ярьсан бөгөөд мөн орчин үеийн уран зохиолд, хутагт хувилгаад, лам хуврагийн дүрийг хэрхэн үзлийн хавцгайд халтируулж, нэгэн цагт өөрсдийг нь хэлмэгдүүлээд, нэхэж одоо сэргээх нэрээр урлагийн бүтээлүүдээр дүрийг нь бас хэлмэгдүүлж байгааг Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав, Өндөр гэгээн Занабазар, Ноён хутагт Данзанравжаа, Шадар ван Чингүнжав нарын тухай гарсан уран сайхны кино, зохиолуудын дүр дүрслэл, түүхэн үнэний зөрүү хоёрыг нүүрэлдүүлэн шүүмжилж бичсэн байна. Ийнхүү «Дуун, утгын яруу зохист» ном бол бүхэлдээ монгол үндэсний уран сайхны сэтгэлгээний хэв маяг аман соёл, аман билгээр яаж уламжлагдаж ирсэн юм, эдүгээгийн уран зохиолын сэтгэлгээ яруу найраг, үргэлжилсэн үгэнд хэрхэн уламжлагдав, хэрхэн хувьсаж өөрчлөгдөв, энэ сэтгэлгээний уламжлалыг хэрхэн хадгалж үлдэх, хэрхэн танин мэдэх, уран зохиол уран сайхны сэтгэлгээг судлахын тухайд ялангуяа аман бичгийн уран зохиолын сэтгэлгээний энэ харилцаа холбоог яаж гаргах ёстой юм бэ, яаж авч үзэх ёстой юм бэ гэдэг нэгэн цогц асуултад хариулт болсон, улмаар уран зохиолын уламжлал шинэчлэл гэдгийг ингэж сэтгэлгээний уламжлалаар нь хөөж үзэх болохоос, он цаг, сайндаа төрөл зүйл, хэлбэр, агуулга, дүр дүрслэл төдийгөөр хайрцаглаж ийшээ нэг, тийшээ нэг салгаж ярин цаана нь үлдэх мөн чанарын хариултыг ололгүйгээр боть ботиор номлохдоо биш юм гэлгийг харуулсан нэгэн цогц судалгааны бүтээл болсон юм.

Л.Хүрэлбаатар багш 1986 онд анх Дорноговь аймагт очиж тэр үеийн нутгийн хөгшдөөс Данзанравжаагийн ховор чухал гар бичмэлүүдийг олж үзэж байсан цагаас нааш хорь гаруй жилийн хөдөлмөр шингэсэн Равжаа судлалын гол бүтээл «Аварга могойн зулайн чандмань» номоо 2006 онд хэвлүүлжээ. Номын оршилд тэрээр “Равжаагийн тухай” бус, Равжааг судалснаа, судлахдаа шашин номын үзэлтээс нь цэвэрлэж бус, харин тэрхүү үзэлтээр нь түлхүүр хийж, гагц Равжааг бус, Равжааг бэлтгэж өгсөн Энэтхэг, Төвдийн шашин номын мэргэдийн үзэл санааны уламжлалтай холбож, чингэхдээ дан гагц монгол сурвалжаар нь бус, төвд олон сурвалжтай нь холбон судалснаа өгүүлсэн бөгөөд могойг нь хараад, зулайд нь буй чандманийг нь хараагүйн үлгэртэй адил, Равжааг “галзуу согтуу” гэж хараад, Равжаагийн судал, хий, дуслын нууц бясалгалын эрдмийг нь хараагүй, тухайн цаг үеийн алдааг ёгтлон өгүүлсэн зохиогчийн алдартай шүүмжийн зохиолын нэрээр ийнхүү номоо нэрлэжээ. Хэдийгээр хорьдугаар зууны эхэн дунд үеэс хойш Данзанравжаагийн зохиол бүтээлийг хэвлэн нийтлэх, түүх намтарт нь холбогдох мэдээ сурвалжийг эрж хайх ажлууд мэр сэр хийгдэж, улмаар Ц.Дамдинсүрэн, Д.Цагаан нарын эрдэмтдийн олон жилийн судалгааны үр дүнд түүний намтар уран бүтээлийн тоймыг олон нийтэд хүргээд байгаа хэдий ч, ялангуяа 1990-ээд оноос хойш Равжаа судлалын ажилд эндүү ташаа зүйлс нэлээд гарсныг нэгбүрчлэн нягталж номын эхэнд өгүүлсэн нь судалгаа шинжилгээний ач холбогдолтой зүйл болжээ. Ноён хутагтын нэрийг буруу ташаа янз бүрээр бичих, төрсөн

64 Л.Хүрэлбаатар. Анхдугаар богд.УБ., 2001.18.

болон нас барсан оныг ташаарах, түүнийг буддийн гүн ухаантан, яруу найрагч, соён гэгээрүүлэгч гэхээс гадна хөгжмийн зохиолч, сийлбэрч барималч, түүх зохиогч, сурах бичиг зохиогч, оточ эм зүйч гээд судалгаа шинжилгээний гүйцэд баримт нотолгоогүйгээр олон зүйлийг хамаатуулан түүнээсээ гол зүйлийг ялган харалгүй самгардуулах, хэвлэгдээд байгаа гэрэл зургууд зөрүүтэй маргаантай болсон, мөн “Өвгөн шувуу”, “Ичиг ичиг” зохиолуудыг нь эх бичиг сурвалж судлалын баримтгүйгээр өөр бусдын зохиол гэж эндүүрэх, алив зохиол бүтээлийг нь шашин номын бүрхэвчээс нь салгаж андуу ташаа тайлбарлах, тэр ч бүү хэл өөрийнх нь байгуулсан Галбын гурван хийд, Ухаа аргалын хийд, Чогзалын хийдийн талаар “Ноён хутагт ламын дүрүүдийн дараалсан дамжлага” сударт “насан сүүдэр арван гурваас дөчин нэгийг хүртэл таван хийдийг байгуулсан” хэмээн өгүүлсээр атал даруй хорь шахам хийдийг байгуулсан мэтээр бичсэн зэрэг олон тооны эндүү ташаарал гарсныг дурдан, тэр бүрийг түүхэн сурвалж баримтаар нь няцаан өгүүлсэн нь чухамдаа төдийгөөс эдүгээг хүртэл явж ирсэн Равжаа судлалын ажилд шинжлэх ухааны өөр өөр түвшний, өөр өөр мэргэжлийн янз бүрийн хүмүүсийн гаргасан алдаа эндэл байна, үүнийг цаашид засч залруулах ёстой, ингэхийн тулд эх бичиг сурвалж судлал, шашин номын үзэл хандалтын зөв голдрилоор орохгүй бол цагийг эзэлсэн энэ их хүмүүнийг судлаад байгаа юм шиг хэр нь улам бүрхэгдүүлээд байж ч болох энэ үзлийн гэмийг таслан зогсоох, улмаар Равжаагийн тухай биш, Равжааг судлах жинхэнэ шинжилгээ судалгааны ул суурьтай ажиллагаа явуулах хэрэгтэйг цагийг нь олж сануулсан хэрэг болсон юм. Мөн номын хоёрдугаар бүлэгт Ноён хутагтын зохиол бүтээлийн судалгааг нь голлон, “Үржинхандын орноос Дулдуйт ажаагийн дунд хувилсан нь” бүлэгт “Хурмаст тэнгэр” тэргүүтэн ихэвчлэн иргэний уянгын дуу шүлгээр нь дамжуулан түүнийг шашин нийгмийн шинэтгэх үзэлтэн байсныг нь, “Амрыг эрэн яруухан донгодох айлтгал бичгийн хөхөө шувуу...” бүлэгт Алшаа лхарамба Агвандандар, Данзанравжаа хоёрын харилцсан захиа бичгүүдээр дамжуулан түүний Бурханы шашны улааны урсгалыг баримтлагч, агь тарнийн эрдэм увидсыг нь түлхэн өгүүлсэн бол, ““Дагинасын гансруулах буцаалтын горим” хэмээх бүжиг цамын тэмдэглэл”, ““Илбийн наадам» хэмээх төвдөөр эгшиглэсэн дэвтэр” тэргүүтнээр дамжуулан түүний яруу найргийн буддийн гүн ухаан, номын ертөнцийн хоёр ёсны үзэл баримтлал тэргүүтнийг, “«Аварга могойн зулайн чандмань» авагч хүмүүн түүнээс хамаарна” бүлэгт арвис тарнийн ухааны тааллын шимийг шүтэхийн учир, судрын ёс тарнийн ёсыг хослон тэтгэхийн учир, энэ хоёр ёсыг хэтийдүүлэн салгаж улаан шар хэмээн зааглаж хориг саадыг үүсгэн үзлийн хавцгайд шахсан тэр цагийн гэмийг номхтогхын тулд нууц тарнийн ёсыг хиргүй ариунаар барих, тэтгэх, арвитгахын тухайд энэ ёсонд орохын анх тулгар номлол болгож энэхүү нууцын зохиолыг бичих болсны учир тэргүүтнийг өгүүлжээ. Зохиолын гуравдугаар бүлэгт Равжаагийн “их” буюу “дэлгэрэнгүй” намтар, товч намтар, намтарт холбогдох аман хуучийн мэдээ, эд өлгийн болоод ном судрын дурсгалууд, байгуулсан орон хийдийн шүтэлцээ учир холбогдол, шашин төрийн үүрэг оролцооны талаар өгүүлж, улмаар номын дөрөв, тавдугаар бүлэгт дүгээр бүлэгт, «Тавдугаар ноён гэгээнтний цэдгийн товч хураангуй оршив» хэмээх бичмэл намтарын 180 гаруй үг утгын буруу уншилттай эхийг ариутган, шашин номын болон түүхэн, хуучирсан үг хэллэг 300 орчмыг тайлбарлаж, шинэчлэн засварлаж, эрдэм шинжилгээний галиг, сийрүүлэг, монгол бичгийн хуулбар, хүмүүн бодгаль, газар орон, сүм хийд, ном судар, шашин номын зан үйлийн тусгай нэрсийн хэлхээг хийж хавсарган хэвлүүлсэн байна.

XX зууны монгол судлал, тэр дундаа Монголын эртний уран зохиол, төвд хэлт уран зохиолын судлал, улмаар Монголын шашин, соёл, буддийн гүн ухааны судлал, Энэтхэг, Төвд, Монголын уран зохиол, шашин соёлын харилцааны чиглэлээр гүнзгийрэн хөгжсөн Л.Хүрэлбаатар багшийн судалгаа шинжилгээний бүтээлүүд шинжлэх ухааны өргөн

дэлгэр цараагаараа, судалгаа шинжилгээний нарийн нягт арга зүйгээрээ, эх бичиг сурвалж судлалын арвин их өв сангаараа энэ цагийн дэлхийн монгол судлалд өндөр байр суурь эзэлж, энэ чиглэлийн эрдэм судлалын ажлын чиг баримжааг ямагт илтгэсээр байдаг юм.

Ном зүй

1. Аман зохиол судлал. УБ., 1977. Х боть. 4-р дэвтэр.
2. Аман зохиол судлал. УБ., 1987. XVII боть. II дэвтэр
3. Ардын эрх. 1998 оны 7-р сарын 23. № 1 (1950)
4. Билгийн толь- II. «Монголын уран зохиолын дээжис». УБ., 1998 «Буддийн судлал», Цуврал 1. Эрхэлсэн доктор, профессор Н.Хавх, дэд профессор Ш.Чоймаа, Л.Чулуунбаатар. УБ., 1998.
5. Билгүүн судар сонин. 1996 оны есдүгээр сарын 24. Дугаар 23(33)
6. БНМАУ-ын шинжлэх ухааны байгууллагын 60, ШУА-ийн 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын сэдэв. УБ., 1981.
7. Буддийн судлал (МУИС, Буддийн соёлын төв). Цуврал 1. УБ., 1998.
8. Брагри ёнзин Дамцагдорж –Монголын шашин соёлын нэрт зүтгэлтэн. УБ., 2001.
9. Гесериада фольклор в современной культуре. Улан-Удэ., 1995.
10. Гесериада –духовное наследие народов Центральной Азии. Международная научная конференция. Улан-Удэ., 1995.
11. Дорно дахины судлалын асуудал. УБ., 1988. №2.
12. Зарубежный Восток. Литературная панорама. Выпуск семнадцати, Москва., 1989.
13. “Засгийн газрын мэдээ” сонин. 1994 оны 4-р сарын 4. Дугаар 27(173)
14. Засгийн газрын мэдээ сонин. 1994 оны 8 сарын 26. Дугаар 64(210)
15. Зууны мэдээ сонин. 2005 оны 7 сарын 7. Дугаар 162(1985).
16. Ил товчоо сонин. 1995 оны 1 сарын 1-10. Дугаар 1(130).
17. Ил товчоо сонин. 1995 оны 12 сарын 1-10. Дугаар 34 (182).
18. Ил товчоо сонин. 1996 оны 4-р сарын 11-20. Дугаар 11(195).
19. Ил товчоо сонин. 1996 оны 7 сарын 11-20. № 20 (204).
20. Ил товчоо сонин. 1997 оны 1-18. 25. № 3/222
21. Ламын гэгээн Лувсанданзанжалцан (1639-1704) Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1999.
22. Монголын судлал. III(II) боть. 21-р дэвтэр. УБ., 1975.
23. Монголын судлал. IX боть. 15-р дэвтэр. УБ., 1981 (1982).
24. Монголын судлал. IX боть. 15-р дэвтэр. УБ., 1981 (1982).
25. Монголын судлал. XIII (21) боть. 9-р дэвтэр. УБ., 1987;
26. Монгол ба Энэтхэг. Улаанбаатар., 1989.
27. Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies). 1. Сөүл., 2002.
28. Mongolica (An International annual of Mongol Studies). Vol 2/23/. 3/24/. 1991. 1992. Ulaanbaatar.
29. Mong!ol sudulul-un bicig (“Papers on Mongol Studies”). № 28. Ulaanbaatar., 1982.
30. МУИС, МХСС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Боть XV (153). XXI дэвтэр. УБ., 1999.
31. Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ 4. Сөүл., 1995.
32. Монгол судлалын мэдээ. IAMS Bulletin. УБ., 1998.
33. Монгол хэл шинжлэл (Улсын Багшийн Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг). Дугаар 1. УБ., 1996.
34. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн «Эрдэм» сонин. 2006 он. Дугаар 03(95).
35. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн «Эрдэм» сонин. 2006 он. Дугаар 05 (97).
36. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн «Эрдэм» сонин. 2005 он. Дугаар 04(84)
37. Нацагдоржийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Бээжин., 2006 оны 12 дугаар сарын 1.
38. Олон улсын монголч эрдэмтний III их хурал. III боть. УБ., 1979.

39. Олон улсын монголч эрдэмтний IV их хурал. II боть. УБ., 1985.
40. Орчуулах эрдэм. Дугаар 4. УБ., 1986.
41. Орчуулах эрдэм. Дугаар 6. УБ., 1989.
42. Олон улсын монголч эрдэмтдийн IX их хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2007.
43. Өвөрмонголын Нийгмийн Шинжлэх Ухаан. 3.4. Дугаар 46, 47. Хөххот., 1990.
44. Өнөөдрийн монгол сонин. 2005 оны долдугаар сарын 7. Пүрэв гараг. Дугаар 48(48)
45. Реферативный журнал (Общественные науки за рубежом, Литературоведение). Серия 7. Москва., 1984.
46. Связи индийской, тибетской и монгольской дидактической поэзий-«Актуальные проблемы современного монголоведение». УБ., 1987.
47. Суутандаа түүх хайртай. УБ., 1998.
48. Төв Азийн тууль. Редактор доктор Д.Цэдэв. УБ., 1998.
49. Утга зохиол, урлаг сонин. № 23. 1990. VI. 1(1737).
50. Утга зохиол, урлаг сонин. 1989.IV.7. № 15 (1697)
51. Утга зохиолын шүүмжлэл-86. УБ., 1989.
52. Утга зохиол судлалын унших бичиг. 1. Улаанбаатар., 1996.
53. Хэл зохиол судлал. XI боть. 22-р дэвтэр. УБ., 1975.
54. Хэл зохиол судлал. XIII боть. 25-р дэвтэр. УБ., 1977 (79).
55. Хэл зохиол судлал. XIV боть. 23-р дэвтэр. УБ., 1978 (80).
56. Хэл зохиол судлал. XX боть. II дэвтэр. УБ., 1987.
57. Хэл зохиол судлал. XX боть. 4-р дэвтэр. УБ., 1987.
58. Хоёр их хутагт (Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын тухай)”. УБ., 1995.
59. Халхын ноён хутагт Лувсанданзанравжай судлал. Улаанбаатар., 2006.
60. Цог сэтгүүл. УБ., 1989. №2.
61. Чин сүзэгт номунхан Лувсанноровшарав. УБ., 2001.
62. Shambhala. 2006 он. 10 сар. Дугаар 001.
63. Shambhala. 2006 он. 10 сар. Дугаар 001.
64. Шинжлэх ухааны академийн мэдээ. УБ., 1985. №3.
65. Шинжлэх ухааны академийн мэдээ. УБ., 1986. №2.
66. Quaestiones Mongolorum Disputatae. № 1, Executive Editors: H.Futaki, B.Oyunbilig. Association for International Studies of Mongolian Culture. Tokyo., April 30, 2005.
67. Хүрэлбаатар.Л Энтэхэг, Төвд, монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо.УБ.,1987.
68. Хүрэлбаатар.Л Сонгодог уламжлал, монгол яруу найраг. УБ.,1989.
69. Хүрэлбаатар.Л Алтан хүрдэн.УБ.,1992.
70. Хүрэлбаатар.Л Сайн үгсийн сан.УБ.,1995.
71. Хүрэлбаатар.Л Монгол орчуулгын товчоон.УБ.,1995.
72. Хүрэлбаатар.Л Огторгуйн цагаан гарди I.УБ.,1996.
73. Хүрэлбаатар.Л Огторгуйн цагаан гарди II.УБ.,2008.
74. Хүрэлбаатар.Л Бакүла ринбүчи Түвдэнчогнор.УБ.,1999.
75. Хүрэлбаатар.Л Эсэруагийн эгшиг дуун.УБ.,1999.
76. Хүрэлбаатар.Л Анхдугаар богд. УБ.,2001.
77. Хүрэлбаатар.Л Судар шастирын билиг.УБ.,2002.
78. Хүрэлбаатар.Л Дуун, утгын яруу зохист.УБ.,2005.
79. Хүрэлбаатар.Л Аварга могойн зулайн чандмань.УБ.,2006.
80. Хүрэлбаатар.Л Дорно Цаст.УБ.,2009.